

Хөгжлийн төр ба орчин үе

Аюурзанын Цанжид

Доктор (Sc.D), профессор

Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс

tsanjid@mas.ac.mn

Хураангуй

Энэхүү өгүүлэлд хөгжлийн төрийн тухай ойлголт, түүний үүсэл, хэв маяг, туршлага, Монгол Улсад хөгжлийн төр буй болох боломжийн тухай асуудлыг авч үзлээ. Орчин үед хөгжиж буй орнуудын харьцангуй амжилттай байгаа хэсэг нь “гүйцэх” стратегийг ямар нэг хэмжээгээр баримталж байгаа ба төр нь ямар нэг хэмжээгээр хөгжлийн төрийн хэв маягтай байна. Тэдгээр нь улс орон бүрд өөр өөрийн онцлогтой байдаг учраас судлаачид янз бүрийн хэв маяг, загвар болгон ангилсан байдаг. Ийнхүү ангилсан нь хөгжлийн төрийн өөрийн орны онцлогт нийцүүлэн буй болгох бодлого, үйл ажиллагаанд арга зүйн ач холбогдолтой юм. Ардчилал гүнзгийрсэн улс оронд Зүүн Азийн “бюрократ” маягийн хөгжлийн төрийг буй болгох боломжгүй, харин “уян хатан” гэж судлаачдын нэрлэдэг хэв маягт багтах өөрийн өвөрмөц загварыг буй болгох боломжтой юм. Хөгжлийн төр ямар ч хэв загварын байсан түүний гол онцлог бол шинжлэх ухаан, технологи, инновацад суурилсан хөгжлийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх явдал юм.

Хөгжлийн төрийг буй болгоход эхний ээлжид анхаарах зүйл бол ШУТИ-д суурилсан хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх гол гол арга хэрэгслийн талаар нийгмийн өргөн хүрээтэй зөвшилцөл хийх, төрийн албаны чадвар, ёс зүйг сайжруулах, хөгжлийн “тархи” –н үүрэг гүйцэтгэдэг бүтэцтэй болох, улсын шинжлэх ухаан, технологи, инновацийн тогтолцоог бүрдүүлж, хүчтэй дэмжлэг үзүүлэх зэрэг юм.

Түлхүүр үгс: Хөгжлийн төр, гүйцэх стратеги, хөгжлийн төрийн хэв маяг, загварууд. Төрийн “араатан” хэв маяг, хөгжлийн төрийн “бюрократ”, “уян хатан” хэв маягууд. Баруун Европ, Азийн загвар

Developmental state and modernity

Tsanjid Ayurzana

Doctor (Sc.D), professor

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

tsanjid@mas.ac.mn

Abstract:

This paper discusses the concept of developmental state, its origin, style, experience and possibility of developmental state in Mongolia. Nowadays, the relatively successful part of developing countries adhere to the “catching-up development” strategy to some extent, and the government adheres to the style of developmental state to some extent. Since each country has different characteristics, researchers have categorized them into different styles and models. This categorization has methodological implications for a developing state’s policies and activities that fit the characteristics of its own country. It is not possible to create a “bureaucratic” East Asian developmental state in a deep democracy, but it is possible to create its own unique model of what researchers call “flexible”.

Whatever the form of the developmental state, its main feature is the formulation and implementation of development policies based on science, technology and innovation. To create a developmental state, the first thing to focus on is to build a broad public consensus on a SHUTI-based development policy and the basic means of its implementation, improve the skills and ethics of the public service, create a structure that acts as a developmental brain and develop public science, building and providing strong support for science, technology and innovation systems.

Keywords: *Development state, catching-up development strategy, styles and models of development state. “Beast” style of the state, “bureaucratic” and “flexible” styles of state development. Western Europe, Asian model*

I. Оршил

Төр бол хувийн өмчийн шөнийн манаач хэмээх үзэл нэгэнтээ хуучирч зөвхөн эдийн засгийн ухааны түүхтэй танилцаж эхэлж байгаа гэнэн хүмүүсийн яриа болжээ. ХХ зууны 90-ээд оноос эдийн засгийн хөгжил дэх төрийн үүрэг нөлөөний тухай үзэл өөрчлөгдсөн юм. Дэлхийн Банкны 1997 оны илтгэлд “Сайн төртэй байх нь тансаглал бус, эдийн засгийн хөгжлийн зайлшгүй шаардлага мөн” гэжээ. Хөгжиж буй орнуудын баримталж буй гүйцэх стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “хөгжлийн төр” хэмээх ойлголт буй болж, өргөн хэрэглэгдэж байна. Хамгийн ерөнхий байдлаар тодорхойлох юм бол хөгжлийн төр гэдэг нь улс орондоо модернизаци хийхийн тулд эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцдог төр юм. Хөгжлийн төр хэмээх ойлголтод эрдэмтэд олон тодорхойлолт өгсөн байдаг боловч үндсэн санаа нь төстэй байдаг. Өмөр Моллаер “хөгжлийн төр гэдэг бол капиталист ангийн янз бүрийн сегмент, түүнчлэн үйлдвэрчний эвлэлээс өндөр түвшний бие даасан байдалтай байдаг, институтийн хүчирхэг чадавхтай, эдгээрийн ачаар хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд төрийн оролцоотой цогц бодлогыг

амжилттай хэрэгжүүлдэг гэгддэг төрийн өвөрмөц хэлбэрийг тодорхойлоход хэрэглэгддэг үзэл баримтлал юм” хэмээн тодорхойлжээ (Omer Mollaer, 2016). К.С.Саблин “хөгжлийн төр гэдэг нь нийтийн болон нийтийн маягийн бараа (*жишээлбэл, үйлдвэрлэлийн инновацыг бий болгох үйл явцыг дэмжих нийгмийн инженерийн дэд бүтцийг бий болгох*) бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинэ технологийг хөгжүүлэхэд татаас өгөх, судалгаа, боловсруулалт, дээд мэргэжлийн боловсролын тогтолцоонд хөрөнгө оруулалт хийх, түүнчлэн инновацын хөгжлийн институтийн орчныг бүрдүүлэх үйл явцад идэвхтэй оролцох замаар эдийн засгийн өсөлтийг өдөөж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангадаг төр юм” гэж тодорхойлжээ (К.С. Саблин, 2010).

Хөгжлийн төр хэмээх ойлголтыг анх Чалмерс Жонсон Японы эдийн засгийн амжилтын түүхийг судалсны үндсэн дээр буй болгосон гэдэг. Тэр бээр 1982 онд “ОУХАУЯ ба Японы гайхамшиг. Аж үйлдвэрийн өсөлтийн бодлого. 1925-1975” (MITI and the Japanese miracle. The growth industrial Policy. 1925-1975) гэдэг зохиолоо нийтлүүлж, түүндээ энэхүү “хөгжлийн төр” (developmental state) хэмээх ойлголтыг анх эргэлтэд оруулж, ийм төр байж болох болон байгааг Японы туршлагаар баталсан байна.

Япон улс үндэсний эдийн засгийн кейнсийн капиталист ч биш, социалист ч биш өвөрмөц загварыг буй болгосон аж. Түүнийг судлаачид хөгжилд чиглэсэн капиталист төлөвлөгөөт рациональ загвар хэмээн нэрлэсэн байдаг.

Жонсон болон түүний зам мөрөөр уг асуудлыг судалсан эрдэмтдийн тодорхойлсноор Японы төр нь дараахь хэд хэдэн онцлогоороо өрнөдийн орнуудын төрөөс ялгаатай байсан байна.

- Улс төр, үзэл санааны хүрээнд элитүүд төр ямар байх, хэрхэн ажиллах талаар зөвшилцөл буй болсон аж. Төрд хамгийн шилдэг хүмүүсээс бүрдсэн элит боловсон хүчин ажиллах ёстой гэдэг дээр санал нэгдэж байжээ.
- Төр эдийн засгийг зах зээлийн болон конформист аргыг хослуулан зохицуулах боломжтой байх нь эдийн засгийн удирдах, аж үйлдвэрийн хөгжлийн бодлогод хяналт тавих боломжтой болсон аж.
- Төвлөрөл багатай, хяналт-гэнцвэрийн механизм бүхий нео-либерал төртэй харьцуулахад Японы төр хатуу төвлөрсөн, эдийн засгийн үндсэн үүргүүдийг тодорхой зорилгыг хэрэгжүүлэх ёстой тэргүүлэх яам, агентлагууд хэрэгжүүлнэ. Төрийн ажилтнууд шагнал урамшуулал (өрсөлдөөнт цалин, өсөн дэвших боломж бүхий карьерын урт замнал г.м.) болон хяналт, шийтгэл (авлигын шийтгэл г.м.) хосолсон меритократ зарчмаар ажиллана.
- Төрийн засаглал төвлөрсөн шинжтэй байхын зэрэгцээ хувийн холбоод, хэлэлцүүлгийн зөвлөлүүд, хүн амтай харилцах хөтөлбөрүүд болон нийгэмтэй холбоо тогтоох, хамтран ажиллах албан бус бусад олон арга хэлбэрийг буй болгон ашигладаг байна.

Нэгэнт төрийн бүтэц, үүрэг, эдийн засгийг зохицуулах арга хэрэгслийн талаар улс төрийн элитүүдийн зөвшилцөл буй болсон байдаг болохоор хөгжлийн төрийн шинжүүд нь улс төрийн системийн нь шинж хэмээн үзэж болмоор санагдана.

Зураг. Хөгжлийн төр



Тиймээс “developmental state” хэмээх эл нэр томъёог “хөгжлийн улс” хэмээн ухаж болох юм.

Хөгжлийн төрийн онцлог шинж нь дээрх зурагт дүрсэлсэн тойргуудын голын давхацсан хэсэгт оршиж байна гэж болох юм. Энд иргэний нийгэм, бизнесийн төлөөллүүдийн төрийн бодлогод оролцох боломж, төрөөс хөгжлийн бодлогын хэрэгжилтэд тавих хяналт, үйлдвэрчний эвлэл болон иргэдийн төлөөллийн байгууллагуудын нөлөө зэрэг хөгжлийн институтийн хүчин зүйлс давхцаж, улс орны хүчин чармайлтыг дайчлан нэг зүгт чиглүүлж байдаг гэж үзэж болно. Гэвч иргэний нийгмийн хөгжил ямар байх зэргээс шалтгаалан дээрх дүрсэлэл улс орнуудад янз бүр байх нь ойлгомжтой юм.

Хөгжлийн төрийн тухай дээр дурдсан тодорхойлолтуудаас харахад нэгд, төр хувийн хэвшлээс болон үйлдвэрчний эвлэл зэргээс харьцангуй бие даасан, хараат бус байх атлаа тэдгээртэй нягт холбоотой байж, хөгжлийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлдэг нь онцлог юм. Үүнд институтийн чадавх гол нөлөөтэй байдаг байна. К.С. Саблиний тэмдэглэснээр хөгжлийн төрд өнгөц харвал эсрэг тэсрэг мэт атлаа бие биеэ нөхдөг хоёр хандлага байдаг аж. Нэг нь төрийг төлөөлж буй ажилтнууд албан тушаалын байр сууриа ашиглан хувийн эрх ашгаа дээд зэргээр хангах эрмэлзэлтэй байдаг гэж үзэх эдийн засгийн онолын хандлага аж. Үүнийг тэр бээр Евансийг дагалдан “араатны” хандлага хэмээн нэрлэжээ. Ийм шинж төрд бүхэлд нь байж болдог тухай хойно арай дэлгэрэнгүй авч үзэх болно. Энэ хандлага Ж.Бьюкенен, Г.Таллока, У.Нисканен, М.Олсон, Э.Крюгер, Д.Мюллер зэрэг өрнөдийн олон судлаачдын бүтээлд илрэлээ олжээ. Хоёр дахь нь төрийн ажилтнууд нийгмийн сонирхлыг чухалчлан эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах замаар хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлдэг гэж үздэг хандлага юм. Энэ талаар А.Амсен, Б.Камингз, М.Кастельс Н.Флигстин, П.Эванс, А.Ведеман зэрэг олон судлаач бичсэн ажээ. Төрийн ямар ч аппарат “араатны” болон хөгжлийн төрийн шинж чанарыг агуулж байдаг байна. Гагцхүү аль шинж нь давамгайлж байх нь тухайн улсын институтийн орчноос хамааралтай ажээ. Саблин эл хоёр шинж бие биеэ нөхдөг гэж бичсэнийг бодвол институтийн орчныг зохистой

бүрдүүлснээр төрийн ажилтнуудын үйл ажиллагаанд хувийн болон нийтийн сонирхлыг хослуулах боломжийг бүрдүүлсэн институтийн орчныг бүрдүүлж болдог байна гэсэн үг юм. Хөгжлийн төр бүхий гэж үзэгддэг улс орнуудын төрд үнэхээр ийм шинж чанар байгаа нь ажиглагддаг. Петер Еванс “*дүгнэж хэлбэл, хувийн эрх ашигийн максимчлал нь зах зээлийн үл үзэгдэх гараар илэрдэг хувийн чадвараар бус хууль дүрэмд захирагдах замаар хэрэгжиж байх ёстой*” хэмээн бичсэн нь хөгжлийн төрийн ажилтнууд чухам ийнхүү хувийн, байгууллагын болон нийтийн сонирхлыг хослуулах замаар хувийн амжилтад хүрдэг гэдгийг ажигласан хэрэг юм (Peter B. Evans. 1989, 573).

Төрийн аппаратад хэдийгээр хувь хүмүүс ажилладаг боловч энэ бол нэгэн организм, ажилтнуудаас бүрддэг том институт юм. Түүнийг нийгмийн тусын тулд ажиллуулахын тулд хувийн сонирхлыг нийтийн сонирхлыг хэрэгжүүлэхэд чиглүүлэхэд чухамхүү хууль, дүрэм, түүний бодитой хэрэгжилт, хэрэгжилтэд тавих хяналт маш чухал юм. Ийм хууль дүрэм нь төрийн аппаратад ажиллаж буй хувь хүмүүсийн үйл ажиллагааг стандартчилж, аппаратыг нийтийн ашиг сонирхолд үйлчилдэг организм болгон хувиргаж чадна. Энэ нь хэн бүхний хэлж чадах амархан үндэслэл боловч, түүнийг хэрэгжүүлэх нь тийм ч амар биш. Үүнийг хэрэгжүүлж чадсан төр хөгжилд манлайлж чаддаг бол чадаагүй нь, авлига, клиентелизм зэрэг сөрөг үзэгдлийн торонд орооцолдож улс орон хохирдог байна. Үүнтэй холбоотойгоор П.Евансийн 1989 онд бичсэн нэгэн өгүүллийг дурдах нь авч үзэж байгаа сэдвийг тодруулахад тустай юм (Peter B. Evans, 1989).

Неоутилитар хандлагын дагуу хөгжиж буй орнуудын түүх, институтийн талаар хийсэн судалгаанд төрийн аппаратын зохицуулах үүрэг төдийгүй энтрепренер үйл ажиллагаа эдийн засгийн өөрчлөлтөд нөлөөтэй байдаг гэсэн дүгнэлтийг авч үзэх нь зүйтэй хэмээн тэмдэглэсэн байна. Төр болгон ижил биш. Хэмжээ, хэлбэр, арга барилаараа ялгаатай боловч төр болгонд хувийн эрх хонжоо хайж, хууль бус ашиг орлого олдог хүмүүс байдгийн зэрэгцээ эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулдаг нь бас бий ажээ. Харин хэргийн учир бол энэ хоёр чанарын аль нь давамгайлж байна гэдэгт оршино.

Ийм арга зүйн үүднээс Еванс төрүүдийг “араатан төр”(predator), “хөгжлийн төр” (developmental state) ба бусад (other) хэмээн ангилжээ. Тэр бээр араатан төрийг тодорхойлохдоо “Зарим улсууд өөрөөр хөрөнгө оруулалт хийх боломжтой ийм их хэмжээний илүүдэл мөнгө зарцуулаад хариуд нь маш бага “хамтын бараа” буй болгодог нь эдийн засгийн өөрчлөлтөд үнэхээр саад учруулдаг. Эдгээр мужуудыг “араатан” гэж нэрлэх нь үндэслэлтэй юм шиг санагддаг.” Ийнхүү их хэмжээний мөнгө зарцуулаад нийтийн ашиг тусад үйлчлэх бага хэмжээний үр дүн гаргадгийн цаана илүүдэл мөнгийг хувьдаа завшиж байгаа юм. Еванс Зайр улсыг ийм араатан маягийн улсын жишээ болгон нэрлэжээ. Энэ нь 1980 –аад оны эхний байдлыг хэлж байгаа хэрэг юм. Еванс цааш нь “төрийн аппаратыг хяналтдаа байлгадаг хүмүүс иргэдийн сайн сайхны төлөө араатан түүний золиос болсон амьтныхаа төлөө санаа тавьдгаас төдийлөн их санаа тавихгүйгээр дээрэмддэг бололтой” хэмээжээ (Peter Evans, 1989, 562).

“Гэвч бусад улсууд хувийн элитүүдийн дунд урт хугацааны бизнес эрхлэх хэтийн төлөвийг бий болгож, өөрчлөлтийн төлөөх хөрөнгө оруулалтад оролцох

хөшүүргийг нэмэгдүүлж, ийм хөрөнгө оруулалтад оролцсоноос гарах эрсдэлийг бууруулж байдаг. Тэдгээр улсууд “ашиг хайхаас” эсвэл нийгмийн илүүдлийн зарим хэсгийг нийт нийгмийн төлөө бус албаны хүмүүс, тэдний найз нөхдийн сонирхлыг хангах зорилгоор ашиглахаас хамгаалалтай байж чаддаггүй боловч эцсийн дүндээ тэдний үйл ажиллагааны үр дагавар нь өөрчлөлтөд саад болдоггүй, харин түүнийг дэмждэг байна. Тэд зүй ёсоор “хөгжлийн төр” хэмээн нэрлэгдэнэ” (мөн тэнд). Зүүн Азийн Шинээр аж үйлдвэржсэн орнууд ийм төрлийн төрүүдтэй хэмээн тооцогддог байна. “Туравдагч ертөнцийн ихэнх орнууд “бусад аппарат”-тай байдаг. Араатны болон хөгжлийн үйл ажиллагааны хоорондын зааг нь тодорхой бус боловч цаг хугацааны явцад харилцан адилгүй бөгөөд ямар төрлийн үйл ажиллагаа хийхийг оролдсоноос хамаарна. Бразил бол “дундын” байдлын тодорхой жишээ юм”.

Дэлхий ертөнцийн байдал өнгөрсөн зууны 70, 80 – аад оныхоос өөр болсон боловч Евансийн тодорхойлсон дээрх дүр зураг ямар нэг хэмжээгээр хадгалагдсаар байна. Хөгжлийн төр бүхий улсын тоо төдийлөн их нэмэгдээгүй боловч араатны болон дундаж маягийн төртэй улс орнууд цөөн биш.

Институтийн орчин нь ямар нэг хүн шинээр зохиодог зүйл биш. Тэр нь тухайн улсын түүх, соёлоос улбаатай байдаг. Түүний онцлогоос хамааран төрийн үйл ажиллагаа хөгжил, өөрчлөлтөд түлхэц болох эсвэл “араатан” юм уу “дундын” шинжтэй байх гэсэн сонголтууд буй болдог байна. Түүх-соёлын уламжлалыг хөгжлийн шинэ зорилгыг хэрэгжүүлэхэд үйлчилдэг болгож болдог байна. Үүнтэй холбоотойгоор төрийн аппаратын (чухамдаа төрийн) загварын тухай асуудал хөндөгдөнө.

Дэлхий дээр “гүйцэх” стратегийг амжилттай хэрэгжүүлсэн орны тоонд БНСУ, Тайван, Финлянд, Ирланд гэх мэт хэд хэдэн орон ордог. Хятад улс бол сүүлийн үеийн гайхалтай бөгөөд өвөрмөц жишээ юм. Дашрамд дурдахад Хятадаас бусад нь хил нь урт биш, эдийн засгийн орон зай нь их нягт, институтийн нэгдмэл (унифицированный) орчинтой, нэгдмэл байгууламжтай, хөгжлийн захиргааны ажилтнуудыг меритократ зарчмаар шилэн сонгодог зэрэг нийтлэг талтай ажээ (К.С.Саблин, 2010, 33). Саблин эдгээр орны институтийг хоёр өөр загвартай хэмээн үзсэн байна.

- Баруун Европын загвар (Ирланд, Финлянд). Энэхүү загварын гол шинж нь хөгжлийн үйл явцад оролцож буй талуудын зөрчлөөс сэргийлдэг дүрэм журмууд аж. Хөгжлийн хэмээх тодотголтой захиргааны ажилтнууд нь маш тодорхой дүрэм журмыг баримтлан бизнес эрхлэгчидтэй хамтран ажилладаг аж.
- Зүүн Азийн загвар (Өмнөд Солонгос, Тайван). Түүний гол шинж нь хөгжлийн захиргааны ажилтнууд болон эдийн засгийн модернизаци хийх сонирхолтой ажил хэрэгч хүмүүсийн сонирхол “уусан нийлсэн” байдалтай, хооронд нь андын харилцаа тогтсон байдаг нь аж (Crony capitalism). Хачирхалтай нь авлигын сувгууд байхаар барахгүй, эдийн засгийн хөгжилд тустай байдаг аж. Видиманы бичсэнээр ийм авлигын сувгууд нь бүр эхнээсээ хөгжлийн стратегид суусан байдаг байна. Том компаниуд (Chaebol) хөнгөлөлттэй зээл, төрийн санхүүжилттэй ажлыг гэрээлэх эрх зэрэг төрөөс олгодог давуу талуудыг эдэлдэг байна. Харин хариуд нь намын санхүүжилтэд “сайн

дураараа” хандив өргөдөг гэнэ.

- Финляндын эдийн засгийн өсөлтийн замнал Азийн баруудынхтай ерөнхий зарчмаараа адилавар боловч, хэрэгжүүлсэн арга барил нь өөр юм. Тус орны хэрэгжүүлсэн өндөр өсөлтийн загварын эдийн засаг, институтийн талын онцлог нь дараахь зүйлд оршиж байжээ.
- “капиталын хуримтлалын өндөр нормыг төрийн хөрөнгө оруулалтын өндөр нормоор дэмжиж байв. Төрийн хэвшил нь эдийн засагт чухал хөрөнгө оруулагч байжээ.
- Цаас, целлюлоз, металл боловсруулах зэрэг болон боловсруулах үйлдвэрлэлийн бусад чухал салбарт хөрөнгө оруулалт их байсан аж.
- Хадгаламж эзэмшигчид болон өрхийн аж ахуйг хохироох замаар хатуу тогтоосон бага хүүтэй зээлтэй, захиргаа нь бизнесийн зарим салбарт зээлийг хуваарилдаг байсан. Ийнхүү төрөөс зээлийн хүүг тогтоож байсан нь инфляц өсөж, хөрөнгийг өрхийн аж ахуйгаас зээлдэгч үйлдвэрүүд рүү урсахад хүргэж байжээ.
- Өсөлтийн дундаж хурдац эрчимтэй байсан боловч, өсөлтийн замнал жигд бус байв. Кейнсизмын “алтан үе” нэгдэж байсан хугацаанд Финляндын бизнесийн цикл их хэцүү байсан” (Marcus Jantti, Juhana Vartiainen, 2009, 5).

Ийнхүү судлаачид Финляндын эдийн засгийн өсөлтийг эдийн засагт дахь төрийн оролцоо их байсантай нэг талаар холбон үзэж байна. Аж үйлдвэрийн тэргүүлэх салбаруудад бага хүүтэй зээлийг төрөөс зориуд хуваарилан олгодог, фермерүүд болон хадгаламж эзэмшигчдийг орлогыг хязгаарлаж байсан болон цалинг ч бас тодорхой хугацаанд царцааж байсан аж. Төр өөрөө эдийн засагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийдэг байжээ. Жантти, Вартиаинен нар Финляндын эдийн засгийн стратегийг “төрийн өндөр оролцоо болон хувийн хэвшлийн урамшуулал хоёрын хослол” (mix of heavy governmental intervention and private incentives) хэмээн тодорхойлсон байна (мөн тэнд). 1950 –иад оны сүүлчээр ч гэсэн Финлянд нь ХАА давамгайлсан орон байсан ба хүн амын тэн хагас нь энэ салбарт ажилладаг, нийт бүтээгдэхүүний 40 хувь нь анхдагч салбарт хамаарч байжээ. Амд ногдох ҮНБ нь Шведийн үзүүлэлтийн талтай тэнцэж байсан байна. Гэвч 1970-аад оны сүүлч гэхэд тус улс аж үйлдвэржсэн орон болон хувирсан аж. Тэр бээр амд ногдох ҮНБ -ээрээ 1980 -аад онд Их Британийг, 1990-ээд онд Шведийг гүйцсэн байна. Финляндын хөгжлийн бодлогыг ‘etatist-dirigiste’ нэрлэдэг байна.

Финляндын эдийн засгийн өсөлтөд дээр дурдсан төрийн оролцооноос гадна:

- төр-бизнес (банкнууд болон том бизнес) - хөдөлмөрийн харилцан ойлголцолд, зөвшилцөл,
- улс төрийн зөвшилцөл,
- Улс төрийн манлайлал,
- Гадаад орны нөлөө гэх мэт бусад хүчин зүйлс ч бас багтаж байсан байна.

Гурван талын зөвшилцөл нь чухамдаа нэгэн төрлийн нийгмийн гэрээ байсан аж. Төрийн хөрөнгө оруулалтын төвшнийг өндөр байлгахын тулд татвар бас их

байсан байна. Түүнээс гадна цалин бага байсан нөхцөлд ийм зөвшилцөлгүйгээр эдийн засгийн өсөлт гаргах бодлого амжилтад хүрэхгүй юм. Үүнд ажилчин ангид нөлөөтэй байсан зүүний намууд болон Үйлдвэрчний эвлэлүүд тодорхой үүрэг гүйцэтгэсэн байна.

Улс төрийн манлайллын хувьд Ерөнхийлөгч Урхо Калева Кекконен чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэх үндэстэй юм. Тэр бээр 1956 – 1982 оны хооронд тус улсын ерөнхийлөгчөөр, түүнээс өмнө 1950-1953, 1954-1956 онуудад ерөнхий сайдаар ажиллаж байжээ. Түүнийг “авторитар” маягийн удирдагч хэмээн үздэг боловч улс орныхоо хөгжил дэвшлийг удирдан жолоодож амжилтад хүргэсэн, олон улсад нэр хүндтэй удирдагч байсан юм. Тэр бээр 1952 онд “Бидэнд хөгжих тэвчээр байна уу?” (Onko maallame malttia vaurastua? –Фин.) гэсэн гарчигтай өгүүлэл бичсэн нь ‘etatist-dirigiste’ бодлогыг тунхагласан хэрэг байжээ.

Тэр үе бол хүйтэн дайн ид хүчээ авч байсан цаг байсны дээр Финлянд улс өмнө нь хараат байж, дайтаж байсан ЗХУ-тай ойр хиллэж байсан зэрэг нь хөгжлийн төлөө бүх нийтээрээ хүчээ дайчлах хэрэгцээг буй болгосон гадаад нөхцөл байжээ.

Эдийн засгийн хөгжлөөр гүйцэх Европ маягийн бодлогыг хэрэгжүүлсэн хоёр дахь орон бол Ирланд юм. Хойт Европын эдгээр орнуудыг “Целтик бар” (Celtic Tiger) хэмээн нэрлэж байна. Тэгэхдээ Ирландын хөгжлийн стратеги нь даяаршлын үед хэрэгжсэн, Финляндынхаас өөр бөгөөд төрийн шинж чанар ч өөр юм. Судлаачид Ирландын эдийн засгийн өсөлтийг нэгд, тус орны компаниудын суралцах чадвартай, Хоёрт, төрийн бодлого, үйл ажиллагаатай холбон тайлбарлаж байна. “Ирландын амжилт нь Ирландын пүүсүүд төвлөрсөн бус Пост-Фордист үйлдвэрлэлийн сургамжаас суралцах болон сургалтын үр ашиг, инновацыг дэмжих орон нутгийн холбоог бий болгох чадварт оршиж байжээ” (Charles Sabel, Ireland: Local Partnerships and social innovation (Paris, OECD, 1996)

Даяаршлын нөхцөлд глобал урсгал болон сүлжээнд маш түргэн бөгөөд сайн нэгдэж чадвал янз бүрийн сонголт байж болох аж. “Төр орон нутгийн болон дэлхий дахины сүлжээний эдгээр хэсгүүдээс хөгжлийн сайн юм уу тааруу замналыг буй болгох замаар сонголтын хувилбаруудыг төлөвшүүлэхэд үйл явцад гол этгээд нь байдаг” (Sean O’Riain, 2000). Ирландын төр чухам ийм сайн замналыг буй болгож чадсан байна.

Хүснэгт 1. Ирландын эдийн засгийн өсөлт (GDP/GNP), 1992–2000

Он	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000
ДНБ	3.7	2.9	6.8	9.8	7.8	10.8	8.6	10.8	11.5
ҮНБ	2.1	2.9	.6						

Source: Dept of Finance 2002; CSO 2003 (R. Kirby – ээс дам эшлэв)

1990 – ээд онд гарсан Ирландын эдийн засгийн өсөлт нь тэр үеийн эдийн засгийн өсөлтөөрөө тэргүүлж байсан орнуудынхтай харьцуулахуйц төдийгүй жагсаалтын гуравт бичигдэж байжээ.

*Хүснэгт 2. Дэлхийн ДНБ-ий дундаж өсөлтөөрөө хамгийн өндөр байсан улсууд.
1990–2001*

Улс	Өсөлт
Хятад	10.0
Сингапур	7.8
Ирланд	7.6
Вьетнам	7.6
Мозамбик	7.5
Уганда	6.8
Малайз	6.5
Чили	6.4

Эх сурвалж: мөн эндээс дам эшлэв.

Ирланд, Израил улсуудын хөгжлийн төрийг “уян хатан хөгжлийн төр” (Flexible Developmental State – FDS) хэмээн нэрлэдэг болжээ. Шон О’Риэн “уян хатан хөгжлийн төлөв (FDS) нь Постфордист үйлдвэрлэл, инновацын сүлжээг хөгжүүлэх, олон улсын хөрөнгө оруулалтыг татах, эдгээр орон нутгийн болон дэлхийн технологи, бизнесийн сүлжээг хөгжлийг дэмжих арга замаар холбох чадвараараа тодорхойлогддог” хэмээн бичжээ (мөн тэнд). “Эл чадвар нь төрөөс инновац болон олон улсын хөрөнгийн мэргэжлийн удирдлагаар удирдуулсан сүлжээнд нэвтрэн орсон болон энэхүү олон талт бүхэллэгийг үр дүнтэй удирдах боломжийг олгодог уян хатан зохион байгуулалтын бүтцээр дэмжигддэг” байна (Мөн тэнд). Тэгэхээр Ирландын хөгжил бол эдийн засаг талаас нь харвал “глобал” болон өөрийн орны боломжийг хослуулж чадсаны үр дүн байх нь.

Дээр дурдсанаас үзвэл хөгжлийн төр нь цаг хугацааны дотор хувьсан өөрчлөгдөж ирсэн байна. Хэрвээ Зүүн Азийн улсууд, магадгүй Финляндын хөгжлийн төрийг (хэдийгээр зарим ялгаатай ч гэсэн) дэлхийн хоёр дугаар дайны дараа буй болж эдийн засгаа хөгжүүлсэн, бас ч бодлого, арга барилаараа төстэй гэж үзээд нэгэн бүлэгт хамруулах юм бол Ирланд, Израил зэрэг орны хөгжлийн төрийн уян хатан хэмээх тодорхойлолтод багтах өөр нэг бүлэг болох юм. Нөгөө талаар хөгжлийн гэсэн тодотголтой төрүүд уламжлалт зохицуулагч (либераль-неолибераль) төрөөс ялгаатай юм. Энэ ялгааг дараахь байдлаар илэрхийлж болно.

- Зохицуулалтын төр нь чөлөөт зах зээлийн зарчимд суурилна. Эдийн засгийн асуудалд хутгалдан оролцохгүй, зах зээлийн өрсөлдөөнийг зохицуулна. Тиймээс стратегийн төлөвлөгөө гаргаж, аж үйлдвэрийг хөгжүүлэх асуудлыг хүчлэн хөөцөлдөхгүй. Ингэх нь зах зээлийн гажуудал үүсгэх аюултай хэмээн үздэг. Хөгжлийн төр нь улс орноо аж үйлдвэржүүлэх юм уу эдийн засгийн тодорхой салбарыг, тэр ч байтугай тодорхой чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор стратегийн төлөвлөгөөгөөр хэрэгжилтийг удирдана. Тиймээс эдийн засагт гүнзгий оролцоотой байдаг.
- Тэгэхээр зохицуулалтын төр стратеги хандлагатай бус богино хугацааны бодлогоор зохицуулалт хийнэ.
- Санхүүгийн хувьд зохицуулалтын төр нь хөрөнгийн зах зээлд тулгуурлах

бонд гаргах зэрэгт тулгуурлана. Үйл ажиллагаа нь голдуу дотоод зах зээлд чиглэсэн байдалтай байдаг аж. Ийм үед хэрэглээ өндөр, татвар болон халамжийн зардал бага байдаг байна. Тэгвэл хөгжлийн төр нь хэрэглээнд бус хуримтлал, хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр байдгаараа ялгаатай юм.

Хөгжлийн уян хатан төр нь даяаршлаар буй болсон боломжийг ашиглах, эдийн засгийн өсөлтийг дагалдсан ардчиллын гүнзгийрлийн (ялангуяа энэ үзэл баримтлалыг 90-ээд оны сүүлчээр болсон хямралын дараа анхаарах болсон Зүүн Азийн орнуудад) үр дүн гэж ойлгомоор байгаа юм. Хөгжлийн уян хатан төр зохицуулалтын төрөөс ч, хөгжлийн бюрократ төрөөс ч (Зүүн Азид буй болсон уламжлалт хөгжлийн төр) ялгаатай юм.

Хөгжлийн уян хатан төр нь үнэ, ханшийг зохицуулдаггүй, худалдааны саад тогтвор учруулдаггүй, зөвхөн хөгжлийн зохих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд эдийн засагт хөндлөнгөөс оролцдог оролцогоороо неолиберализмд суурилсан зохицуулалтын төртэй адил юм. Харин Зүүн Азийн орнуудыг бар болгосон хүнд суртлын гэж болох хөгжлийн төрөөс ялгаатай нь хөгжлийн уян хатан төр нь эдийн засагт бага хэмжээгээр, уян хатан байдлаар хөндлөнгөөс оролцдог. Хөгжлийн уян хатан байдал нь төсвийн хатуу зарлага, цалингийн зохистой түвшнийг хадгалах болон гадаадын хөрөнгө оруулалтыг татах үйл ажиллагаанд суурилдаг.

Иймд хөгжлийн уян хатан төрийн бодлогод санхүү талдаа төсвийн хатуу зарлага, татварыг бууруулах, цалинг царцаах зэрэг бодлого багтдаг бол нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогод нь дэд бүтцийг бий болгох төрийн төлөвлөгөөний дагуу боловсрол, сургалтыг сайжруулах ажил багтдаг байна.

Хөгжлийн төрийн өмнөх хэв маягийн үед томоохон аж ахуйн нэгжүүдийг голлон дэмждэг. Харин уян хатан төр нь түүнээс гадна жижиг, дунд бизнесийг дэмждэг байна.

Хөгжлийн уян хатан төрийн гүйцэтгэдэг үүргийг товч тодорхойлбол тэр нь чиглүүлэгч юм. Өөр нэг үүрэг нь бизнес эрхлэгчдэд боломж олгодог явдал юм.

- корпорациудыг дэмжиж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж, дотоодын бизнесүүдэд дэлхийн үйлдвэрлэлд оролцох боломжийг олгодог.
- нийгмийн түншлэлийг бий болгосноор хөдөлмөрийн зах зээлд уян хатан цалин хөлсийг баталгаажуулдаг. Ингэснээр дотоодын бизнесүүдийг аж үйлдвэрийн шинэ салбарт өрсөлдөх чадвартай болгодог байна.
- уян хатан хөгжлийн төр үйлдвэрлэлийн сүлжээ, технологийн инновацыг бий болгож, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, орон нутгийн бизнесийг үндэстэн дамнасан корпорациудтай холбож, хөгжлийг дэмждэг. Засгийн газрын уян хатан бүтэц, орон нутаг болон үндэстэн дамнасан корпорацийн уялдаа холбоогоор дамжуулан эдийн засгаа үр дүнтэй удирдах чадвартай болдог байна. Хөгжлийн уян хатан төрүүд үндэстэн дамнасан корпорациудын талаарх мэдээллийг орон нутгийн бизнесүүдэд өгч, холбодог байна. Харин энэ мэдээллийг ашиглан бизнесээ хөгжүүлэх үүрэг орон нутгийн бизнесүүдэд ногддог байна.
- Улс орнууд макро эдийн засгийн бодлогоороо үндэстэн дамнасан корпорациудад урамшуулал бий болгодог байна. Макро эдийн засгийн

бодлогыг тогтвортой байлгах, өмчийн эрхийг баталгаажуулахын зэрэгцээ үнийг гажуудуулах, худалдаа, хөрөнгө оруулалтад саад болдоггүй байх ёстой ажээ. Дэд бүтцийг буй болгох, үндэстэн дамнасан корпорацуудын хөрөнгө оруулалтад таатай орчин бүрдүүлэхэд чиглэгддэг.

- Дүгнэж хэлбэл уян хатан хөгжлийн төрийн үндсэн үүрэг нь хөгжлийг дэд бүтцээр хангах, зах зээлийн эрх чөлөөг баталгаажуулах замаар хязгаарлагдах аж. Мөн хүний нөөцийг төлөвшүүлэх, технологийг сайжруулах, уян хатан хөдөлмөрийн зах зээлийг бий болгоход анхаарах ёстой аж.

Хөгжлийн уян хатан төрийн хувьд эдгээр үүргийг гүйцэтгэх нь хөгжлийн бюрократ төртэй харьцуулахад хялбар биш. Зөвхөн хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдлыг хангах, цалин тодорхой түвшинд барих асуудал л гэхэд эсэргүүцэл тэмцэлтэй тулгарах болно. Энэ асуудлыг шийдвэрлэх арга нь мөн л төр, бизнес, үйлдвэрчний эвлэл хооронд хэлэлцээрээр түншлэлийг буй болгох явдал юм. Энэ нь үндэсний хэмжээний зөвшилцөл гэсэн үг юм. Үйл ажиллагааны ийм арга барил нь эцсийн дүндээ талуудын аль алинд ашигтай байдлыг буй болгодог байна. Улс орон бүхэлдээ хөгжих нь төрийн зорилго мөн. Харин ажлын байр нэмэгдэж, ажилгүйдэл буурдаг учраас хөдөлмөрийн талдаа, үйлдвэрчний эвлэлүүдэд ч ашигтай болно.

Ийнхүү гүйцэх стратегийг хэрэгжүүлж амжилтад хүрсэн орнуудын хөгжлийн төр (бюрократ), хөгжлийн уян хатан төр гэсэн хоёр хэв маягийн төрийн талаар товч авч үзлээ. Өнөөгийн дэлхий дахины болон Монгол Улсын нөхцөлд төрийн ажилтнууд бизнесийн харилцан үйлчлэх авлигын маягийн тогтолцоо, зээлийн хүүг бага түвшинд хүчээр барих, бага хүүтэй зээлийг хаягаар хуваарилах, цалинг хэт бага төвшинд удаан хугацаагаар царцаах гэх мэт арга хэрэгслийг ашиглах боломжгүй юм. Гэвч хөгжлийн төрийн дээрх загваруудаас дараахь зүйлийг туршлага хэмээн үзэж болох юм.

- эдийг засгийн үзүүлэлтэд стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан дэмжлэг авсан аж ахуйн нэгж байгууллага, хүмүүсээс заавал үр дүн нэхэх,
- Дотоодын үйлдвэрүүдийг олон улсын тэргүүний технологитой үйлдвэрүүдтэй холбох, тэдэнд холбоо харилцаа тогтоох боломж бүрдүүлэх,
- Гадаадын хөрөнгө оруулалтад макро эдийн засгийн тогтвортой байдал, өмчийн эрх, зах зээлийн бодит харилцааг баталгаажуулах гэх мэт болон бусад боломжийг бүрдүүлэх,
- Хөгжлийн стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үндэсний зөвшилцлийг буй болгох,
- Шинжлэх ухаан, боловсролыг дэмжих,
- Төр, захиргааны бүтцийг уян хатан болгох гэх мэт.

Судлаачид хөгжлийн төрийн үеийн аппаратыг Веберийн маягийн хэмээн тодорхойлох нь элбэг. Веберийн тодорхойлсон аппарат нь цэвэр (идеал) хэв шинж учраас амьдралд цэвэр байдлаар нь буй болгох боломжгүй юм. Гэвч аливаа юмны хөгжил бол цэвэр төлөв рүү гээ тэмүүлж байдаг. Хөгжлийн төрүүдийн аппарат нь бусадтай харьцуулахад цэвэр төлөв рүү гээ илүү дөхсөн гэсэн үг юм.

Дээрх загваруудын аль нь ч манай улсад тохирохгүй байж болно. Гэвч өөрийн орны өвөрмөц нөхцөлийг харгалзсан Монгол маягийн хөгжлийн төрийг буй болгоход эдгээрээс санаа авах зүйл байгаа нь эргэлзээгүй юм. Ийнхүү хөгжлийн төрийн өөрийн загвартай болох нь олон талт яриа хэлэлцээний асуудал юм. Хөгжлийн загвар нь гүйцэх стратегийг баримталж байгаа улс орнуудын хувьд тэргүүлэх зорилготой нь уялдаатай байдаг нь ажиглагдаж байгаа юм. Нөгөө талаар орчин үеийн нөхцөл байдал нь Азийн барууд өсөж өндийсөн өнгөрсөн зууны хоёр дугаар хагас төдийгүй, Целтик баруудын буй болсон үеийнхээс өөр болж байгааг харгалзах шаардлагатай болж байна. Тухайлж заримаас нь дурдвал:

- дэлхийн эдийн засгийн бүтэц өөрчлөгдөж байна. Үйлдвэрлэл тэргүүлэх байр эзэлж ирсэн бол улс орнуудын эдийн засаг, мэдлэгийн, үйлчилгээний тал руу хэвийх хандлагатай болж байна. Дэлхий дахин хөгжлийн нийгмийн чиг баримжаатай инновацад суурилсан загварт шилжиж байна. Улс орнууд ялгаатай байгаа боловч энэ нь нийтлэг хандлага болж байна. Гэвч дэлхий дахинд болж байгаа өөрчлөлтүүд эдийн засаг, нийгмийн хөгжилд эерэг, сөрөг нөлөөтэйн дээр тодорхойгүй байдлыг буй болгож байна.
- Дэлхийд шинэ шинэ тусгаар улсууд нэмэгдэж, улс орнууд, ялангуяа коронавируст цар тахлын үеэс “амиа бодох” хандлагатай боллоо. Гэвч ийм хандлагын зэрэгцээ тоон технологи, дэлхий дахиныг хамарсан мэдээллийн сүлжээ, худалдаа зэрэг нь түүний эсрэг үйлчлэлтэй байна. Дэлхий дахины хуваагдал, бүлэглэлийн өнөөгийн байдал гадаад орчин хэрхэн өөрчлөгдөхийг тааварлахын аргагүй болгож байна.
- Техник, технологийн үеүд богино хугацаанд солигдож, хөгжиж буй орнуудын хувьд тэдгээрийг “хөөж гүйцэхэд” бэрхшээлтэй байна. Улмаар хөгжиж буй орнууд болон хөгжилтэй орнуудын ялгаа улам ихсэх, “зарим улс дэлхий дахины хөгжлийн их замын хажууд зогсон үлдэх” аюул тулгарч байна.
- Дэлхий дахинд хөрөнгө оруулалт, мэргэжилтэй ажиллах хүчний төлөөх өрсөлдөөн хүчтэй болж байна.
- Шинэ техник, технологи нь эдийн засгийн хүчин чадал багатай орнуудад ч тэдгээрийг нэвтрүүлэх, ашиглах боломжийг олгож байгаа ба гагцхүү зөв сонголт хийх хэрэгтэй байна.
- Том үйлдвэрүүдээс гадна жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлт гаргах боломж буй болсон байна.
- Цаг уурын дулаарал, хүрээлэн буй орчны өөрчлөлтийг хөгжлийн стратегид зүй ёсоор харгалзахыг шаардаж байна.
- Дотоод болон гадаад улс төрийн нөхцөл байдал ч өөрчлөгдөж байна.

Дэлхий дээр геополитикоос үүдэлтэй зөрчил хурцдаж байна. Дотоодод хүмүүсийн мэдлэг боловсрол, авч байгаа мэдээллийн хэмжээ нэмэгдсэн болон нийгмийн сүлжээ зэрэг харилцааны хэрэгсэл буй болсон нь олон нийтийн улс төрийн идэвхийг өсгөсөн юм. Түүгээр ч зогсохгүй экстремист хандлага буй болж байна. Эдгээр нь үндэсний зөвшилцөл буй болоход ихээхэн саад болно. Улс төрийн өрсөлдөөний улмаас эрх барьж буй хүчнүүд богино хугацаанд үр дүн гаргах эрмэлзэлтэй байгаа нь урт хугацааны стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхэд саадтай байгаа юм. Одоогийн нөхцөл байдлаас дүгнэлт хийвэл ойрын ирээдүйд

засгийн газрууд нэгд, иргэдийн зүгээс төрд итгэх итгэл маш бага, хоёрт, эсэргүүцэл, зөрчил ихтэй хуйларсан (turbulent) уур амьсгал бүхий орчинд ажиллах болно.

Эдгээр хүчин зүйлс нь эдийн засгийн хөгжлийн төдийгүй нийгэм-улс төрийн хөгжлийн талаар үндэсний үзэл баримтлалыг шаардаж байгаа юм.

Манай орны нөхцөл байдал нь Зүүн Азийн хөгжлийн бюрократ буй болж байсан тэр үеийнхээс өөр юм. Ийм тохиолдолд хөгжлийн уян хатан төр хэмээн нэрлэгддэг тэр загварыг Монголын онцлогтойгоор буй болгохыг оролдох сонголт л үлдэж байна. Үүний тулд юуны өмнө дараахь асуудлуудад анхаарал тавих нь зүйтэй бололтой.

- Хэдийгээр өнөөгийн нөхцөлд маш төвөгтэй ч гэсэн шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацад суурилсан хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар улс төрийн хүчнүүдийн төдийгүй, маш өргөн хүрээтэй зөвшилцөлд хүрэх нь цорын ганц зам байж болох юм. Ийм зарчим дээр л хөгжлийн төр буй болох бололцоотой юм. Тэгэхдээ энэ бол дээр дурдсан “араатны” хэв маягтай биш байх ёстой нь ойлгомжтой юм. Ингэж чадвал хөгжлийн төртэй болох, улс орон маань бүхэлдээ хөгжилд тэмүүлсэн улс болох боломжтой юм. Ийм зөвшилцөл буй болсноор төвөгтэй асуудлыг шийдвэрлэх бодлого гарах бүрд эсэргүүцэл гарах, засгийн газар солигдох бүрд өмнөх бодлогыг өөрчлөх юмуу үл тоомсорлон орхих гэх мэт болон бусад хүндрэлээс сэргийлэх болно.

Хөгжлийн сайн төртэй нэрлэгддэг улс орнуудын туршлагаас үзэхэд юуны өмнө төрийн албаны шинж чанар маш чухал юм. Явал төрийн алба хаагчид хувийн болон нийтийн сонирхлыг зөв хослуулж, албан үүргээ хэрэгжүүлдэг болгох вэ гэдэг асуултад хариулт хэрэгтэй аж. Үүний дараа л зөв бүтэц гэх мэт бусад асуудлыг ярьж болно. Орчин үеэс жишээ авах юм бол БНХАУ энэ талаар их үр дүнд хүрч байгаа гэж болно. Feina Cai Хятад бол орчин үед гарч ирж байгаа хөгжлийн төвийн жишээ мөн гэдгийг тэмдэглээд хоёр зүйлийг онцолсны нэг нь Хятадын үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо нөгөө нь хятадын төрийн албаны өрсөлдөөнт шинж юм. “Үүнээс гадна эдийн засгийн албаны ажилтнууд нь өндөр мэргэшсэн байдаг. Иймээс төрийн албанд ажиллах нь Хятадын ихэнх хүмүүсийн сонирхлыг татдаг уламжлалтай. Төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалт нь маш их өрсөлдөөнтэй байдаг. Жил бүрийн Үндэсний төрийн албаны шалгалтаар аль болох олон хүнээс сонгохыг эрмэлздэг. Төрийн албан тушаалд маш сайн, тохирох хүмүүсийг шилж сонгохыг эрмэлздэг ба, өрсөлдөөн их байдаг. Хятадын Төв Телевизийн (CCTV, 2009) мэдээлснээр 2009 оны шалгалтад 1.35 сая орчим өргөдөл гаргагч хамрагдах болзол хангасан нь 2003 оныхоос 15 дахин их байсан нь шинэ дээд амжилтыг тогтоожээ. Эдгээр хүмүүс 150 мянган орон тооны төлөө тэмцсэн. бөгөөд ерэн хүн тутмын нэг нь л мөрөөдлөө биелүүлж чадна гэсэн үг” хэмээн бичжээ (Feina Cai. <https://www.e-ir.info/2010/12/22/the-developmental-state-in-the-globalizing-world/>) Манай улсын судлаачдаас ч Хятад бол “хөгжлийн төр” –ийн загвар болох боломж байна хэмээн үзэж байна (<http://mongol.cri.cn/20210728/5d383eaa-44d0-c56c-c911-a690cc65cf1a.html>). Ричард Виетор Сингапурын төрийн алба хаагчид “бидний үүрэг бол бизнест үйлчлэх” гэж хэлдэг бөгөөд ингэж ярьж байхыг өөр хаана ч сонсоогүй гэж бичжээ. Гэвч энэ асуудал

хоёр талтай. Өндөр чадвартай хүмүүсийг шударга бөгөөд сэтгэлтэй ажиллуулахын тулд нийгмийн асуудлыг нь зохих төвшинд шийдвэрлэсэн байх учиртай.

Хөгжлийн “уураг тархи” –ийн үүрэг гүйцэтгэх байгууллагатай болох. Шинжлэх ухааны болон бизнесийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг, хөгжлийн бодлогыг боловсруулдаг, гүйцэтгэлийг хянадаг, залруулдаг, ирээдүйг төлөвлөдөг, Засгийн газраас харьцангуй бие даасан байгууллага байна хэмээн төсөөлөгдөж байгаа юм. Манайд засгийн газрын бүтцэд багтдаг яам, хороо байгуулж байгаа нь дөрвөн жилийн настай, ажиллагсад нь солигдож байдаг, бодлого нь зөвшилцөлд тулгуурлаагүй байдаг зэргээс үүдэн хөгжлийн “уураг тархи” болж чадахгүй байна хэмээн ажиглагддаг.

Шинжлэх ухаан, технологи, инновацын үндэсний цогцолборыг бүрдүүлэн, хүчтэй дэмжлэг үзүүлэх. Хэдийгээр орчин үед шинжлэх ухаан, технологийн ололт хэрэглээнд түргэн нэвтэрч байгаа ч гэсэн салбарын онцлог бол мэдлэг, туршлага хуримтлагдах үйл явц тодорхой цаг хугацаа эзэлдэг учраас цаг алдаж болохгүй юм.

Ашигласан ном зохиол

Вистор, Ричард Х.К. Улс орнуудын өрсөлдөөн. Даяаршлын үеийн эдийн засгийн стратеги, бүтэц ба засгийн газар. УБ., 2014

Мөнхжаргал О, Ж. Төртөгтох. Хөгжлийн улс төр ба түүний арга зүй. *Политологи* №20 (570) 49-59

Эрдэнэбаяр М. “Хөгжлийн төр засаг загвар” болж төлөвших боломж өндөр байна. <http://mongol.cri.cn/20210728/5d383eaa-44d0-c56c-c911-a690cc65cf1a.html>

Cai, Feina. The Developmental State in the Globalizing World. <https://www.e-ir.info/2010/12/22/the-developmental-state-in-the-globalizing-world/>

Evans, Peter B. Predatory, Developmental, and Other Apparatuses: A Comparative Political Economy Perspective on the Third World State. *Sociological Forum*, Vol. 4, No 4, Special Issue: Comparative National Development: Theory and Facts for the 1990s. (Dec. 1989), pp.561-587. courses.washington.edu/pbaf531/Evans_Predatory.pdf

Jantti, Markus and Juhana Vartainen. The Finnish Developmental State and its Growth Regime. June 2009

United Nations University

<https://www.wider.unu.edu/publication/finnish-dev...>

Mollaer, Omer. Developmental State: A Theoretical and Methodological Critique. *Bulletin of Economic Theory and Analysis*, 2016, 1(1), 1-12.

O’Riain, Sean. The Flexible Developmental State: Globalization, Information Technology, and the “Celtic Tiger” DOI: 10.1177/0032329200028002002 https://www.researchgate.net/publication/236144191_The_Flexible_Developmental_State_Globalization_Information_Technology_and_the_Celtic_Tiger/link/00b7d5314ce8cf3046000000/download

Rogers, Everett M. *Diffusion of Innovations*. 3rd Ed. Free Press. NY, 1983.

“World Bank. 1997. World Development Report 1997: The State in a Changing World. © New York: Oxford University Press. <http://hdl.handle.net/10986/5980>

Левин С. Н., Саблин К.С. (2021). Догоняющее развитие vs. //Journal of Economic Regulation (Вопросы регулирования экономики) 12(4)Д 60-70 DOI: 10.17835/2078-5429.2021.12.4.060-070

Саблин К.С. Государство развития в разных институциональных условиях. Journal of Institutional Studies. 2010, Том 2, №4